



МАНДАЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-04-30 № САА-2020/ХА-04-08
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Мандал сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Мандал сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Мандал сумын Монгол Ардын намын хорооны Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мандал сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /.....Э..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Мандал сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН ИТХ-ЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**МАНДАЛ СУМ
2020 ОН**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

АЗ ЖАРГАЛТАЙ МАНДАЛЧУУДЫН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ

Мандал сум иргэдээ дээдэлж, өрхөө дэмжих, эдийн засгийн өсөлтэд тулгуурласан хүн төвтэй бодлого хэрэгжүүлснээр **ИРЭЭДҮЙ НЬ ТЭРЭЛТЭЙ - ИРГЭД НЬ ЖАРГАЛТАЙ СУМ** болно.

Үйл ажиллагааны үндсэн **ЗОРИЛТУУД**:

1. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨВ ТЭГШ ГЭР БУЛ
2. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ – ХАНГАЛУУН АМЬДРАЛ
3. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ – ШИЛДЭГ ШИЙДЭЛ
4. НОГООН ХӨГЖИЛ – ЭЭЛТЭЙ ОРЧИН
5. ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ – ЦАХИМЖСАН ҮЙЛЧИЛГЭЭ 5 бүлэг 108 багц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

НЭГ: НИЙГМИЙН ХӨГЖИЛ- ӨВ ТЭГШ ГЭР БУЛ

1.1 ЭРҮҮЛ МЭНД - СПОРТ

- 1.1.1 “ЭРҮҮЛ ИРГЭН 2024” хөтөлбөрийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.
- 1.1.2 “Чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Хүүхдийн 40 ортой эмнэлэг шинээр барих асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 1.1.4 Нэгдсэн эмнэлгийг нэн шаардлагатай эмч, мэргэжилтэн, багаж, тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.1.5 Эмнэлгийн цаг авах үйлчилгээг утсаар буюу цахимаар авдаг болно.
- 1.1.6 Эмийн бус эмчилгээг өргөжүүлэн сувилал, нөхөн сэргээх төвүүдийг дэмжин ажиллана.
- 1.1.7 55-аас дээш насны эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд ахмадын кабинетаар дугааргүй үйлчилнэ.
- 1.1.8 Мэс заслын эмчилгээнд дурангийн хагалгааг нэвтрүүлнэ.
- 1.1.9 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.1.10 Урьдчилан сэргийлэх үзлэгийн төв байгуулж, иргэдийг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

- 1.1.11 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэн шаардлагатай багаж, тоноғ төхөөрөмжүүдээр үе шаттай хангах, цахим эрүүл мэндийн төв болгох үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 1.1.12 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмчийн хүрэлцээ хангамжийг сайжруулж, Эмнэлгийн тусlamж нэн шаардлагатай иргэдэд гэрээр үзүүлэх тусlamж үйлчилгээг өргөжүүлнэ.
- 1.1.13 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна.
- 1.1.14 Сумын Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулан, Сум орон нутгийнхаа нэрийг гаргаж буй тамирчдаа дэмжин ажиллана.
- 1.1.15 Хэрх тосгонд орчин үеийн стандартад нийцсэн спорт заал барих асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 1.1.16 Төмөр замчдын 1-р багт байршилтай стадионыг сэргээн засварлаж, орчин үеийн стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбайтай болгох асуудлыг дээд шаты байгууллагад уламжилж шийдвэрлүүнэ.

1.2. БОЛОВСРОЛ - СОЁЛ

- 1.2.1. Ерөнхий боловсролын 3-р сургуулийн өргөтгөлийн барилгыг дуусгаж ашиглалтад оруулна.
- 1.2.2. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого чиглэлийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх "**ӨНӨӨДРИЙН ХҮҮХЭД МАРГААШИЙН ИРЭЭДҮЙ**" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.2.3. "Чадварлаг багш" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.2.4. Яслийн үйлчилгээг сэргээж 1-2 насны хүүхдийг хамруулна.
- 1.2.5. Мандал сумын эрэлт хэрэгцээнд шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх Их дээд сургуулийн салбарыг байгуулах саналыг холбогдох газарт уламжилна.
- 1.2.6. Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчныг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.2.7. СӨБ, ЕБС-ийн гадна тоглоомын болон биеийн тамирын талбайг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулна.

1.2.8. Зүүнхараа Политехник коллежийг Спорт заалтай болгох асуудлыг дээд шатны байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

1.2.9 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор шинээр цэцэрлэгүүд барих асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

1.2.10 Ерөнхий боловсролын сургуулиудад шинэ дэвшилтэт технологид нийцсэн тоног төхөөрөмж бүхий байгалийн ухааны лаборатори, нийгмийн ухааны кабинетуудыг байгуулна.

1.2.11 Тарни 8-р багт Соёл спортын цогцолбор байгуулах асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

1.2.12 Орон нутаг судлах музей, номын сан, мини кинотеатр бүхий “ХӨГЖЛИЙН ТӨВ” барьж байгуулах асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

1.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ - ХАМГААЛАЛ

1.3.1 Ахмад настан, ХБИ ажлын байрыг шинээр бий болгон ажиллаж байгаа ААНБ иргэдийг дэмжиж ажиллана.

1.3.2 “Ахмадын сургаал –Алт” сургалтын төвийг ажиллуулна.

1.3.3 Ахмадын сувилалд ажиллах мэргэжилтэй боловсон хүчин, сувиллын орны тоог нэмэгдүүлж, тусlamж үйлчилгээний нэр төрлийг олшруулна.

1.3.4 Халамж үйлчилгээний төв байгуулж тусгай хэрэгцээтэй иргэд, хүүхдэд хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.

1.3.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллах, зорчих нөхцөлийг хангасан стандартын барилга, зам, орчныг бий болгоно.

1.3.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэргээн засах төвийг шинээр нээн ажиллуулна.

1.3.7 Хүчирхийлэл түүний даамжралаас сэргийлж, түр хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжин ажиллана.

1.3.8 Ажлын байрны стрессийг бууруулах, ажиллах эерэг орчин бүрдүүлэх, зөв зохистой харилцаа, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор сэтгэл зүйч ажиллуулна.

ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ – ХАНГАЛУУН АМЬДРАЛ

4317143998
МЮА0065 9055436

2.1 ХӨДӨӨ АЖ АХҮЙ

- 2.1.1 Атрын 4-р аяны хүрээнд техникийн шинэчлэл хийх санал санаачилгыг дэмжиж ургацыг алдагдалгүй богино хугацаанд тарих, хураах боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.2 Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлж, үрийн шинэчлэл хийн үр үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлэх ААН, иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.
- 2.1.3 Эзлжлэн тариалах технологийн дагуу ногоон тэжээл, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.
- 2.1.4 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг дэмжин бүтээгдэхүүн борлуулалтын нэгдсэн системийг бий болгоно.
- 2.1.5 Хүлэмжийн аж ахуйг нэг цэгт төвлөрүүлэн дэд бүтцийг шийдвэрлэнэ.
- 2.1.6 **Зоорины** зориулалтаар иргэдэд газар эзэмшүүлнэ.
- 2.1.7 Хүсэлт гаргасан иргэдэд хүнсний ногооны зориулалтаар 3 хүртэл га газрыг шинээр эзэмшүүлнэ.
- 2.1.8 Малын өтөг, бууц ашиглан орон нутгийн бордоог үйлдвэрлэж газар тариаланд ашиглана.
- 2.1.9 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, шилмэл омгийн малаар сүргийн бүтцийг сайжруулж, фермер байгуулах арга зүйгээр хангана.
- 2.1.10 Өвөлжилт, хаваржилт хүндэrsэн нөхцөлд малчид, мал бүхий иргэдэд хямд үнээр нийлүүлэх өвс тэжээлийн цехтэй болно.
- 2.1.11 Дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж малын гаралтай бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээ бүхий нэгжтэй малчны хороолол байгуулна.
- 2.1.12 Мал, амьтны гоц халдварт өвчний голомт бүхий орон нутгаас ирэх малын хөдөлгөөнд цахим систем ашиглан хяналт тавих, урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллана.

2.2 ҮЙЛДВЭРЛЭЛ-ХУДАЛДАА

- 2.2.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “МАНДАЛД ҮЙЛДВЭРЛЭВ” хөтөлбөрийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.
- 2.2.2 Сумын үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж санхүүжилтийн эх үүсвэрийг зохистой бүрдүүлж хэрэгжүүлнэ.
- 2.2.3 Гар урлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- 2.2.4 Үйлдвэрийн тоног төхөөрөмж сурталчлах үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна.

- 2.2.5 Жижиг дунд үйлдвэрлэлээ өргөжүүлэх шинээр үйлдвэр байгуулах иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.
- 2.2.6 Хүнсний ногооны савласан болон нөөшилсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.
- 2.2.7 Үйлдвэрийн бүсийг шинээр байгуулж, иргэдийн ~~амьдрах орчин~~ нөхцөлд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлнэ.
- 2.2.8 Бичил уурхайчдын олборлосон алтыг Монгол банканд тушаах нөхцөлийг бүрдүүлж, алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээг бий болгох, гарал үүслийг баталгаажуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.9 Стандартад нийцсэн худалдааны зах байгуулах санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 2.2.10 Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч Малын тэжээлийн үйлдвэр байгуулна.
- 2.2.11 Хувийн хэвшлийн байгууллагаас Олон улсын стандартад нийцсэн цэвэр усны үйлдвэр байгуулах ажлыг дэмжин ажиллана.
- 2.2.12 Мал нядалгааны газрыг сумын төвөөс нүүлгэн, орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн мах бэлтгэх үйлдвэр байгуулна.
- 2.2.13 Нөөцийн мах хадгалах зоорины хүчин чадлыг нэмэгдүүлнэ.


2.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 2.3.1 Баялаг бүтээгч хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор сум хөгжлийн сангийн тодорхой хувийг зарцуулна.
- 2.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор АЖЛЫН БАЙР нээлттэй хаалганы өдөрлөгийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.
- 2.3.3 Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд дэмжин ажиллах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.4 Бичил уурхай эрхлэгчдийг шинээр мэргэжил эзэмших, өөр ажлын байртай болоход дэмжлэг үзүүлнэ.
- 2.3.5 Орон нутагт баялаг бүтээгч иргэн, ААН-н бараа бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжинэ.
- 2.3.6 Политехник коллеж төгссөн оюутан залуусыг ААНБ-тай гэрээ байгуулан ажлын байраар хангах, орон нутагт шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх ангийг нэмж байгуулах талаар холбогдох байгууллагад уламжилна.

ГУРАВ: ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ – ШИЛДЭГ ШИЙДЭЛ

3.1 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

- 3.1.1 Аймаг, сум орон нутаг, тосгон, сууринд байрлах ашиглалтын хугацаа дууссан төрийн болон нийтийн орон сууц, барилга байгууламжийн газрыг дахин төлөвлөлтөд оруулна.
- 3.1.2 Мандал сум, Хэрх, Түнхэл тосгодын “Хөгжлийн өрөнхий төлөвлөгөөг” шинэчлэн боловсруулж батлуулна.
- 3.1.3 Иргэнд шинээр өмчлүүлэх, эзэмшүүлэх газрын нөөцийг тогтоож дэд бүтцийг бий болгон газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжинэ.
- 3.1.4 Гудамж, талбай, айл өрхийн хаягжуулалтыг шинэчлэн сайжруулна.
- 3.1.5 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын камержуулалтыг нэмэгдүүлж, нэгдсэн удирдлага-хяналтын системд холбоно.
- 3.1.6 Гэр хорооллыг цэвэр ундны усаар хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж 24 цагийн ажиллагаатай Ухаалаг худгийг 1,6,2,7-р багийн нутаг дэвсгэрт шийдвэрлэнэ.
- 3.1.7 Ундны цэвэр усны шугам, худаг, усан сангудын барилгыг засварлах, шинээр барих, ундны усны эх үүсвэрүүдийг төрийн мэдэлд авч хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөнө.
- 3.1.8 Сумын тэг гортиг суурьшлын бүсийг шинэчлэн тогтооно.



3.2 ХОТ ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЭЦ

- 3.2.1. Гэрэл хорооллын шороон замыг асфальт болон бетон зам болгох асуудлыг үе шаттай хэрэгжүүлж тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийх ажлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 3.2.2 Мандалsumaas Тарни 8-р баг хүртэлх авто замыг сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2.3 Мандал sumaas Түнхэл тосгон чиглэлийн 45 км авто замыг сайжруулсан болон хатуу хучилттай болгох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 3.2.4 Үерийн далан дээгүүрх авто машины гүүрнүүд (1-р сургуулийн баруун талд, Дунд өлөнт, Хэрх тосгонд) шинэчилнэ.
- 3.2.5 Дулааны станц байгуулах ТЭЗҮ зураг төсвийг хийж, холбогдох дээд байгууллагад уламжилна.
- 3.2.6 Гэр хороолол, төмөр замын 1,6-р багийн дан байруудыг дулааны шугамд холбох асуудлыг судлан холбогдох дээд шатны байгууллагад уламжилж үе шаттайгаар шийдвэрлэнэ.

- 3.2.7 Холбогдох дээд шатны байгууллагад уламжилж сумын төвийн Инженерийн шугам сүлжээг нэмэгдүүлэн айл өрх, Аж Ахуйн Нэгж Байгууллагуудыг бохирын шугамд холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2.8 Сум, тосгодын гудамж, замын гэрэлтүүлгийг бүрэн дуусгана.
- 3.2.9 Эрчимжсэн мал аж ахуйн фермерийг бий болгох зорилгоор батлагдсан 180 га газрын дэд бүтцийг бий болгоно.
- 3.2.10 Гэр хорооллын айл өрхүүдийг гурвалсан сүлжээнд (интернэт, утас, телевиз) холбох ажлыг шийдвэрлэнэ.
- 3.2.11 Шинэ суурьшлын бүсүүдийн цахилгааны шугам сүлжээг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 3.2.12 Ус зайлцуулах үерийн далангийн байгууламжийг шинээр төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 3.2.13 Хүүхдийн тоглоомын талбай бүхий цэцэрлэгт хүрээлэнг баг бүрд байгуулна.
- 3.2.14 Төмөр замчдын 1-р багт байрлах 96 айлын орон сууцны дээвэр, 96 айлын орон сууц, Спиртийн 300 айлын орон сууц, Тост өргөө 100 айлын орон сууц, Нархан 18 айлын орон сууцны гадна фасадыг засварлах асуудлыг холбогдох дээд шатны байгууллагын дэмжлэгтэйгээр шийдвэрлэнэ.
- 3.2.15 Хувийн хэвшлийн аж аж ахуйн нэгж, албан байгууллагуудын дэмжлэгтэйгээр 150-аас доошгүй айлын орон сууцыг шинээр барина.
- 3.2.16 Иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг үргэлжлүүлж, эмч, багш, цагдаа, онцгой байдлын албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлтэй орон сууцанд хамруулна.

ДӨРӨВ: НОГООН ХӨГЖИЛ – ЭЭЛТЭЙ ОРЧИН

4.1 БАЙГАЛЬ ОРЧИН

- 4.1.1 Ногоон хөгжлийг дэмжих замаар “Ногоон сум” хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ.
- 4.1.2 Утаагүй түлшний цех байгуулж агаарын бохирдлыг бууруулна.
- 4.1.3 Ногоон байгууламж бүхий “Цэцэрлэгт хүрээлэн”-г гүйлтийн болон дугуйн замтайгаар шинэчлэн тохижуулж иргэдийн амралт зугаалгын бүс болгоно.
- 4.1.4 Хараа голыг бургасжуулах дэд хөтөлбөрийн дагуу хараа голын эрэг дагуух газрыг мод үржүүлгийн чиглэлээр иргэдэд эзэмшүүлнэ.

4.2 ХОГ ХАЯГДАЛ, АГААР, ХӨРСНИЙ БОХИРДОЛ

4.2.1 Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.2.2 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.2.3 Иргэдийн амьдрах орчны сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Зүүнхараа хот, Хэрх, Түнхэл тосгодын хогийн нэгдсэн цэгүүдийг нүүлгэн шилжүүлнэ.

4.2.4 Хөрсний бохирдлоос сэргийлж амралт сувиллын газруудыг боловсон жорлонтой болгох, айл өрхүүдийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэх аян өрнүүлнэ.

4.3 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

4.3.1 Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААНБ-ын үйл ажиллагааг дэмжиж сумын байгалийн үзэсгэлэнт болон түүхэн дурсгалт газруудыг судлан аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлнэ.

ТАВ: ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ – ЦАХИМЖСАН ҮЙЛЧИЛГЭЭ

5.1 НУТГИЙН УДИРДЛАГА

5.1.1 Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй, ил тод байдлыг ханган төрийн мэдээллийн цахим лавлагааны ашиглалтыг сайжруулна.

5.1.2 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал шийдвэр үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.

5.1.2 Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа дэд хөтөлбөрийг батлуулж мөрдөнө.

5.1.4 Гэр хороолол, гудамжны хаягжилтыг эрэмбэ дараатай цэгцлэн, иргэний бүртгэлийн “Хаягийн зөрчил давхардал”-ыг арилгана.

5.3. ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

5.3.1 Арван хоёр жилийн найрамдалт харилцаатай Бүгд найрамдах Солонгос улсын ы-сон сумтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах чиглэлээр хамтран ажиллана.

5.3.2 Бүгд найрамдах Солонгос улсын Үжинбү хотын Шинхан их сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлж оюутан элсүүлэх, багш сурагч солилцоо арга хэмжээг үргэлжлүүлнэ.

5.3.3 Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Бүгд найрамдах Солонгос улсын Чежү хоттой хамтран ажиллана.

5.3.4 Сэлэнгэ аймаг Япон улсын Шизоуки мужийн хамтын ажиллагааны хүрээнд хүлэмжийн аж ахуй эрхлэх гэрээт ажилтан бэлтгэх сургалтад ногоочдыг хамруулна.

Мэрийн хөтөлбөр боловсруулсан
Мандал сумын Монгол Ардын Намын Хороог
төлөөлж
Мандал сумын намын хорооны дарга

Мандал сумын
Монгол Ардын Намын Хорооны дэд дарга



Н.Лхагвадорж

431714399

МЮА0065 9059436

Э.Баярхүү

Мандал сумын
МАН-ын хорооны тэргүүлэгч

Б.Ганболд

Н.Амгаланбаатар
Л.Мөнхбат